

БУДДЫН ШАШИН, ДАЛАЙ ЛАМЫН ТАЛААРХИ МОНГОЛЫН ХАНДЛАГА

*Ш.Догмийчойдон**

Монгол Улс 1990 онд иргэний ардчилсан нийгмийг эрхэмлэн тунхагласнаас хойш олон нийтийн сүсэг бишрэл сэргэж улмаар “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй” хэмээн 1992 онд “Үндсэн хууль”-ндаа хуульчлан тунхагласан юм. Өмнөх нийгмийн үед иргэдийн шүтэн бишрэх эрх чөлөө хаалттай байж, 1946 оноос хойш улсын хэмжээнд ганцхан Гандантэгчинлэн хийд л ажиллаж байсан бөгөөд иргэдийн дийлэнхи олонхи буюу 70 гаруй хувь нь өөрсдийгөө атейст гэж үзэж байжээ.¹ Энэ нь тухайн үеийн нийгмийн тогтолцоо үзэл сурталтай холбоотой. 1921 оны Ардын хувьсгалын дараа шашин сүм хийдийг хавчин гадуурхах, устгах ажил явагдсаны эцэст 700 гаруй сүм хийдийг устгаж 1939 он гэхэд нэг ч сүм хийд ламгүй болон үлдсэн байв.²

Шашин шүтэх эрх чөлөө сэргэснээр үндэсний өв соёл, шашин шүтлэгээ сэргээх эрмэлзлэл нийгмийг хамарч, “Зарим сүм хийдийг сэргээн хамгаалахтай холбогдсон асуудлын тухай”³ (1990.02.22) БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарсанаар 1990 оны 3-р сард “Монголын сүсэгтний холбоо” (буддын), 10-р сард “Монголын мусульманы нийгэмлэг”, 12-р сард “Монголын библийн нийгэмлэг” тус тус байгуулагдан ажиллаж, хурал номын үйл ажиллагаагаа ил, нээлттэй явуулах болжээ. Олон шашны төлөв байдал Улаанбаатар хотноо эхлэн төлөвшсөн бөгөөд казах иргэд голлон аж төрдөг Баян-Өлгий аймгийг эс тооцвол орон нутагт үндсэндээ буддын уламжлалт шарын шашин сэргэж, 1992 он гэхэд Монголын хэмжээнд буддын нийт 95 сүм хийд хурал номын үйл ажиллагаагаа явуулах болсоны 92 нь хөдөө орон нутгийн сүсэгтэн олонд үйлчилж байсан тухай доктор С.Цэдэндамба дурджээ.⁴ Уламжлалт шашин сэргэхийн сацуу уламжлалт бус шашны янз бүрийн урсгал чиглэл Монголд нэвтрэн орж ирэн үйл ажиллагаагаа мөн явуулж эхэлжээ.

Орчин үеийн шашин судлалд уламжлалт ба уламжлалт бус шашин хэмээх ойлголт нэлээд хэрэглэгдэх болсон аж. Энэ тухай “Уламжлалт шашин гэдэг нь үндэсний шашин гэдэгтэй адил төстэй утгатай боловч бас ялгаатай ойлголт юм. Аль нэг угсаатан, үндэстэн, улс оронд түүхийн нэлээд урт удаан хугацаанд оршин тогтнож, үзэл номлол, үйлдэл шүтлэг нь үндэсний уламжлал, ёс заншилд нэвчин шингэж, ахуй амьдралд нь идээшин дасаж, аажмаар тухайн улс үндэстний болон ард түмний соёлын салшгүй содон шинж, үндсэн элемент болон төлөвшиж, улмаар тэр соёлыг дараа үеийнхэнд дамжуулан хэвшүүлж байдаг тийм шашныг уламжлалт шашин гэжээ.

* Ш.Догмийчойдон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Цаг хугацааны хувьд харьцангуй саяхнаас үүссэн үзэл номлол, үйлдэл шүтлэг нь үндэсний уламжлалтай төдий л холбоогүй, ихэвчлэн гаднаас нэвтрэн орж ирж байгаа эсвэл тухайн нийгмийн огцом өөрчлөлт буюу хямралт байдлын үр дагавар болж гарч ирж байгаа, эхэн үедээ нийгмийн зүгээс олонхийн дэмжлэг хүндэтгэлийг төдий л хүлээгээгүй тийм шүтлэгийн хэв маягийг уламжлалт бус шашин”⁵ хэмээн тодорхойлжээ.

Дээрх онолын үүднээс авч үзвэл манай улсын хувьд уламжлалт шашин хэмээн эртнээс уламжилж ирсэн, нөгөө талаас шүтэн бишрэгчдийнхээ тоогоор хүн амын дийлэнхийг хамарсан буддын шашин, эртний уламжлалтай язгуурын шүтлэг болох бөөгийн шашин, мөнхүү хүн амын тодорхой хэсэг буюу угсаатны нэгэн нийтлэг болох казахын уламжлалт шашин исламын шашныг нэрлэж болох тухай доктор С.Цэдэндамба дурдсан байна.⁶

Уламжлалт бус шашинд 1990-ээд оноос хойшхи хугацаанд Монголд орж ирсэн шашны урсгалууд болох христосын чиглэлийн өрнө дахины улбаатай шашнууд, бусад янз бүрийн шашны урсгалууд тухайлан Ананда Марга, Бахайн шашин, Мунийн шашин, Бомбын шашин, Язу гарнийн гэх мэт шашны урсгалуудыг нэрлэж болох юм.

1992 онд Үндсэн хуулиндаа “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэж тодорхой заан улмаар төр шашны харилцааг илүү сайн зохицуулахын үүднээс 1993 онд “Төр сүм хийдийн харилцааны тухай хууль”-ийг баталсан юм. Тус хуулийн хоёрдугаар бүлгийн 4-р зүйлд “Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй”⁷ хэмээн уламжлалт шашин болох Буддын шашны зонхилох байр суурийг тодотгон хуульчлан баталсан юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах дотоод хүчин зүйлийн нэг бол дотоодын түвшинд үндэстэн болон шашин хоорондын зөрчил, сөргөлдөөнгүй байх явдал бөгөөд жижиг улсуудын оршин тогтнолд ийм зөрчил байвал аюул учирдаг.

Энэ ч үүднээс 1994 онд батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Монгол Улсын Үндсэн Хууль нь Монгол Улсын ард иргэд, нийгмийн бүх хэсэг бүлгийн нийтлэг ашиг сонирхлын цогцолсон илэрхийлэл мөн” болохыг зааж “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”⁸ хэмээн тодорхойлсон байна. Язгуур ашиг сонирхолд “Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана”

хэмээн томъёолж үндэсний язгуур ашиг сонирхол төр, ард түмний онцгой анхаарал, хамгаалалтанд байхыг заасан байна.

Уг үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь гадаад, дотоод хэмээн ангилж, II зүйлийн 22-р хэсэгт Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлийн нэгэнд “шашин үндэс угсаа, нутаг орны хурц маргаан, зөрөлдөөн гарах нөхцөл байдал бий болох”⁹ хэмээн тодорхойлжээ.

Хэдийгээр эдүгээ манай улсад бусад зарим улс орны адил шашин хоорондын зөрчил мөргөлдөөн гарах явдал үндсэндээ байхгүй мэт боловч үүнийг нарийвчлан судлах ёстой хэмээн санана.

Манай орны хувьд сүсэгтнүүдийн дийлэнх хувь нь уламжлалт бурханы, исламын, христосын шашныг шүтдэг бөгөөд сүсэгтнүүдийн маш цөөн хувь нь бусад шашныг шүтдэг байна. Яг нарийвчлан хүн амын хэдэн хувь нь ийм шашин шүтдэг гэсэн улсын хэмжээнд гаргасан сүүлийн үеийн тодорхой тоо баримт байхгүй ч, 2004 онд Улаанбаатар хот, 21 аймгийн нийт 1000 шахам иргэдийн дунд НҮБ-ын МХЭХҮХБТ, МУИС-ийн Шашин судлалын тэнхимээс хамтран явуулсан социологийн тодорхой судалгаагаар Монголчуудын шүтдэг гол шашин бурханы шашныг хамгийн олон хүн буюу нийт оролцогчдын 54.6%, ислам шашныг 10.2%, христийн шашныг 7.0% нь талархан хүлээн авдаг¹⁰ гэж хариулсан байна.

2007 оны статистик тоо баримтаар, Монголд нийтдээ 249 сүм хийд байгаа бөгөөд 2004 онтой харьцуулахад 10.7%, 2005 онд 3.8%, 2006 онд 1.6% өссөн, нийт сүм хийдийн 138 буюу 55.4%-ийг будда, 89 буюу 35.7%-ийг христ, 20 буюу 8.0%-ийг ислам, 2 буюу 0.8%-ийг бусад шашны сүм хийд эзэлж байна.¹¹ Эдгээр тоон үзүүлэлтээс харсан ч манай улсад ямар нэгэн шашны үйл ажиллагаа эрхэлдэг сүм хийд, тэдгээрт ажиллагсадын тоо хэмжээ өссөн нэмэгдсэн байх бөгөөд үүний цаана тэр хэмжээгээр итгэгч сүсэгтнүүд хүрээгээ тэлж буй нь лавтай.

Үндэсний аюулгүй байдлыг хангах дотоод хүчин зүйлийн нэг бол дотоодын түвшинд үндэстэн болон шашин хоорондын зөрчил, сөргөлдөөнгүй байх явдал гэдгийг “Аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тодорхой заасан тухай дээр дурдсан. Жижиг улсуудын оршин тогтнолд ийм зөрчил байвал аюул учирдаг. Үүнээс дүгнэлт хийж урьдчилан сэргийлж байх явдал үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалахад онцгой чухал юм.

Онолын хувьд уламжлалт бус шашин гарч ирэх нийгмийн үндсэн шалтгааныг 4 хүчин зүйлээр тайлбарласан байх бөгөөд үүнд:

1. Уламжлалт шашин шүтлэг нь тухайн үеийнхээ нийгмийн өөрчлөлттэй зохицож чадахгүй буюу хүмүүсийн шашин шүтлэгийн шинэ хэрэгцээг төдийлөн хангаж чадахгүй болсон.

2. Тухайн нийгмийн харилцаанд өөрчлөлт гарснаар нийгмийн үнэт зүйлсийн тогтолцоонд, тэр дундаа шашныг үзэх үзэл хандлагад ч өөрчлөлт гардаг. Ингэснээр өмнөх уламжлалт шашны үзэл номлолын агуулгыг шинээр, огт өөрөөр тайлбарлах буюу шашны урд өмнө байсан урсгал чиглэлүүдийн дундаас шинэ шашны урсгал чиглэл гарч ирэх нь бий.

3. Улс хоорондын харилцаа, соёлын солилцооны үр дүнд хүмүүс огт өөр хэв маягийн шашинд сонирхон хандах замаар уламжлалт бус шинэ шашнууд бий болдог байна.

4. Гадаад улс төрийн болон тухайн шашны эрх ашгийн үүднээс аль нэг улс оронд янз бүрийн шашин гаднаас түрэн нэвтрэн орох замаар уламжлалт бус шинэ шашин гарч ирэх явдал байдаг байна. (Энд шашны номлогчдийн үйл ажиллагаа чухал нөлөөтэй байдаг)¹²

Гэвч практик дээр уламжлалт бус шашны хувьд манай хүмүүсийн ядуу амьдралд тус дэм болох нэрийн дор халхавчлан буян өглөг, хандив, тусламжийн эд зүйл тарааж, бэлэн мөнгө оруулан ирж шашны үйл ажиллагаа явуулдаг байр барих буюу түрээслэн авч ажиллуулж байна. Мөн уламжлалт буддын шашин шүтлэг нь хүмүүсийн шашин шүтлэгийн шинэ хэрэгцээг төдийлөн хангаж чадахгүй, шинэчлэл хийх хэрэгтэй болсоныг харуулж байгаа юм.

Уламжлалт бус шашны нөлөө идэвхжиж байгаа нь янз бүрийн үр дагавартай байж болох боловч буддын шашныг нийгмийн идэвхтэй байдалд түлхэн оруулах, үзэл номлолын тайлбарлал, үйл ажиллагаандаа өөрчлөлт хийхэд нөлөө үзүүлэгч хүчин зүйл болж болох юм.

Улсын нийслэл, аймгуудын төвд янз бүрийн шашны сүм, хийд, хурал цуглааны газар нээгдэн ил, далд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Үүнийг тэрбур хянан бүртгэх, зөвшөөрөл олгох ажил дутуу дулимаг хийгдэж байгаагаас гадна төрийн зүгээс тодорхой хяналт байхгүй байна гэхэд хилсдэхгүй.

Гаднаас янз бүрийн шашны урсгал чөлөөтэй нэвтрэн залуу үеийнхэнд нөлөөлөн сүсэгтнүүдийн хүрээг тэлж байгаа нь алсдаа ард түмний эв нэгдлийг сарниулж цөөхөн монголчуудыг олон хуваах, улмаар шашин хоорондын мөргөлдөөнд хүргэж үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй тул болгоомжлох ёстой асуудлын нэг юм.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын ҮШ зүйл “Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал”-ын хэсэгт “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, шашин-сүм хийдийн дотоод хэрэгт төрөөс үл оролцон, жаяг номын нь дагуу чөлөөтэй явуулах, сүм хийдийн тоо, байршил, лам, санваартан нарын үнэмлэхүй тоог төрийн хяналтанд байлгах”, “Шашин хоорондын харилцааны асуудлыг төрийн онцгой анхааралд байлгаж, хямрал мөргөлдөөнөөс сэргийлэх. Аливаа сүм хийдийн үйл ажиллагааг үндэсний соёл иргэншилд хор хохирол үл учруулах хэмжээнд хууль зүйн хүрээнд байлгах” нь соёл иргэншлийн

аюулгүй байдлыг хангах арга замын нэг болохыг тодорхойлсон ч төр, шашны байгууллагыг бүртгэхээс өөрөөр хянах, лам, санваартны байж болох үнэмлэхүй тоог тогтоосон, түүнээс хэтэрвэл хэрхэжийг зохицуулсан эрх зүйн баримт бичиг хараахан үгүй мэт байна. Төрийн бодлого хуулийн заалт сайн хэрэгжихгүй байгаа нь иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах, төр, сүм хийдийн харилцааг зохицуулахад чиглэгдсэн төрийн бодлого, хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий субъектүүдийн үйл ажиллагааны механизм зүгшрэн тогтоогүй, тэр механизм байлаа ч ажиллах эрх зүйн үндэс нь хуульд тодорхой тусаагүйтэй холбоотой.¹³ Тухайлбал 2009 оны 6-р сард Нийслэлийн ИТХ-ын дэргэдэх Шашин, сүм хийдийн асуудал эрхэлсэн зөвлөлөөс “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль” хэрхэн хэрэгжиж байгаа талаар шалгалт хийхэд зөвшөөрөл аваагүй 50 гаруй байгууллага илэрсэн байна.¹⁴

Монгол Улсын Үндсэн хуулийн 9-р зүйлд “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” хэмээн заасан байдаг. Үүнийг зарим нэгэн улс төрийн нам урвуугаар тайлбарлан өнгөрсөн УИХ-ын сонгуулийн сурталчилгаандаа ашигласан боловч золоор тэр намаас сонгогдогч гарсангүй. Үндсэн хуулийн энэ заалт нь эртний шашин, төрийг хослон барих “хос ёсны” тухай сургаал биш бөгөөд харин ч төр шашин хоёрын зааг ялгааг тодотгон улмаар “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль”-д (1993) төрөөс шашны аливаа нэг дотоод хэрэгт оролцохгүй, шашны зүгээс улс төрийн ямар нэг үйл ажиллагаа явуулж үл болохыг баталгаажуулан эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон байдаг.

Уламжлалт буддын шашны сүсэгтэн олон Буддын шашны тэргүүн, хувилгаан гэдэг утгаар Далай ламыг шүтэн биширч улс орондоо урин залж номлол сургаалийг нь сонсохыг хүсдэг ч улс төрийн шалтгаанаар гадны буюу БНХАУ-ын зүгээс янз бүрийн эсэргүүцэлтэй тулгардаг юм. Учир нь 1959 онд Төвдөд дэгдсэн үймээн самуун, зөрчил сөргөлдөөний улмаас Далай лам тойрон хүрээлэгч, шүтлэгтнүүдийнхээ хамт нутгаасаа дүрвэн гарч Энэтхэгийн Дармасалад цагаачлан суурьшиж “Цөллөгөн дэх” Төвдийн засгийн газар хэмээхийг байгуулж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм. Хятадын Засгийн газраас Далай ламыг шашны зүтгэлтэн биш, харин шашинаар халхавч болгож, Хятад улсыг хагалан бутаргах, үндэстний нягтралыг эвдэх ажиллагааг урт хугацаанд хийж ирсэн улс төрийн оргоногч хэмээн үздэг. Далай лам түүний засгийн газар Дармасалад цагаачлан суурьших болсноос хойш хоёр тал янз бүрийн шатанд хэлэлцээ хийхийг эрмэлзэж байв. 1980 оны эхээр Хятадын удирдагч Дэн Сяопин “Төвд бие даасан, тусгаар тогтносон улс биш” гээд Далай ламтай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа мэдэгдэж байв.¹⁵ Түүний хойно 1988 онд Далай лам Францын Страсбург хотноо Европын Парламентэд хэлсэн үгэндээ Төвдийг тусгаар тогтноулах гэсэн шаардлагаасаа татгалзаж байгаагаа мэдэгдээд Төвдөд жинхэнэ утгаар

нь “өөртөө засах эрх” олгох хэрэгтэйг дурдаж байжээ.¹⁶ Хоёр тал янз бүрийн шатанд олон удаа харилцан хэлэлцээ хийх талаар ярилцаж байсан боловч ямар нэгэн тохиролцоонд хүрч чадалгүй байсаар 90-ээд оны дунд үеэс харилцаа бүрэн зогсонги байдалтай байв.

2002 оны 9-р сард Далай ламын Америк дахь тусгай элч Гяри Подойжалцан, Европ дахь тусгай элч Галсанжалцан нарын төлөөлөгчид БНХАУ-д айлчилсан нь 1993 оноос хойш тасраад байсан Далай ламын Засгийн газар болон БНХАУ-ын харилцаанд нэгэн чухал алхам болсон юм. Уг айлчлалын талаар Далай лам Данийн Ерөнхий сайд Андерс Фог Расмуссентэй уулзсаны дараа Копенгаген хотноо 2003 оны 6-р сарын 4-нд хийсэн мэдэгдэлдээ БНХАУ-тай өөрийн төлөөлөгчдийн хийсэн хэлэлцээнд сэтгэл хангалуун байна гээд хэлэлцээний хамгийн гол зорилго нь хоёр тал харилцан итгэлцлийг бий болгох явдал хэмээн онцлон тэмдэглэж “Энэ бол сайн эхлэл юм. Бид нэг Хятад гэсэн зарчмыг баримтлах болно” хэмээж байв.¹⁷ Гэвч үүний дараа 2003 оны 6-р сарын 8-14-нд Далай ламын төлөөлөгчид БНХАУ-д дахин айлчилж албаны хүмүүстэй уулзаж ярилцсан бөгөөд энэ удаагийн яриа хэлэлцээний талаар албан ёсны мэдээлэл гараагүй ч хоёр тал нэлээд олон зүйл дээр санал зөрөлдсөн тухай хэвлэлүүд мэдээлсэн юм.¹⁸

Энэ үеэс Хятад ба Далай ламын хоорондын харилцаа төдийлөн нааштай байж чадаагүй юм. Харин 2008 оны гуравдугаар сарын 14-ний өдөр Лхас хотод болсон жагсаал яваандаа эсэргүүцэх хөдөлгөөн болон хувирсан агаад үүний улмаас Хятадын эрх баригчдын мэдэгдсэнээр нийт 19 хүний амь насыг сүйдэж, (Дарамсалад байгаа Түвдийн дүрвэгсдийн Засгийн газар, гадаадын эх сурвалжууд лавтай 100 орчим хүн амь насаа алдсан гэдэг)¹⁹ 620 гаруй хүнийг гэмтээж, 953 хүнийг саатуулж, 300 гаруй газар гал тавьж, 214 орон сууц, дэлгүүрийг шатааж, бага дунд сургууль руу дайрч сүйтгэсэн үйл явдал болсоны улмаас дэлхийн олонх орны уриалга шахалтын дагуу арга буюу Хятад улсыг Далай ламын төлөөлөгчидтэй хэлэлцээний ширээний ард суухад хүргэсэн. Төвдөд болсон энэ үйл явдлыг дэлхийн олонх оронд эсэргүүцсэн жагсаал цуглаан болж, 2008 оны 8-р сард Хятад улсад болох олимпийн тоглолтыг ч хойшлуулах саналыг зарим улс орон гаргаж байв. Энэхүү үйл явдал ч манай орныг тойрсонгүй БНХАУ-аас манай улсад суугаа Элчин сайдын яамны хашаан дээр улаан будгаар “free Tibet” /Түвдийг чөлөөл/ гэсэн үгсийг бичсэн явдал гарч байлаа. Энэ бүх хэрэг явдлын зохион байгуулагчыг Хятадын эрх баригчид мөн л Далай лам мөн гэж зарласан.

Дээр дурдсан уулзалт урьдын адил бүтэлтэй болоогүй, Далай ламын элч нар хэлэлцэхээр оруулсан олонхи асуудлаар ямар нэгэн зөвшилд хүрч чадаагүйгээ дурдаад “Бидний тохиролцож чадсан цорын ганц зүйл бол дараачийн шатны яриа хэлцээ хийх асуудал байлаа” гэж

мэдэгджээ.²⁰ Хятад, Далай ламын харилцааны талаар барууны зарим шинжээчдийн үзэж байгаагаар “Хятадын эрх баригчид үнэндээ өдгөө өндөр настай Далай ламын хорвоогийн мөнх бусыг үзүүлэхийг нь хүлээж байгаа. Түүнийг бурхны оронд очсон даруйд Түвдийн тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөн бутарч, АНУ, Европынхны анхаарлын төвд байхаа болино” гэдэг.²¹ Энэ тохиолдолд Хятадын Засгийн газар ХҮ Далай ламтай ямар нэг тохиролцоонд хүрэлгүй байж байгаад дараагийн Далай ламыг БНХАУ-ын ТӨЗО-ы дотроос тодруулах сонирхолтой байдаг ажээ. Энэ тухай, бүр Хятадын Засгийн газар 2007 онд баталж есдүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн зарлигаар дахин төрөхөөр төлөвлөж байгаа хутагт, гэгээнтнүүд мэдүүлгээ бөглөж, Засгийн газрын хэд хэдэн агентлаг хэлтэс рүү явуулж батлуулах баримт бичиг ч гаргасан байдаг.²² Түүнд Далай ламын хойд дүрийг өөрсдөө тодруулна гэдгээ шулуухан хэлж “Хэрвээ Хятадын засгийн газар, шашны хэрэг эрхлэх газрын зөвшөөрөлгүйгээр өөрийгөө тунхагласан “амьд бурхан”-ыг хууль бус хэмээн үзэх болно” гэж дурдсан байна. Үүнээс гадна Далай ламын хойд дүрийг тодруулах үйл явц “хилийн чанадад байгаа ямар ч бүлэг, хувь хүний нөлөөн дор явагдах ёсгүй” ажээ.

Харин Далай лам “би Түвдээс гадна, Хятадын эрх баригчдын хяналтаас хол газар төрөх болно. Энэ бол мэдээжийн учир юм. Дахин төрөх, хойд дүр гэдгийн учир утга нь өмнөх дүр нь дуусаагүй үргэлжилж байдагт оршдог. Тиймээс Түвдийн асуудал, бэрхшээл шийдэгдэхгүй хэвээр байвал би дуусгаагүй ажлаа үргэлжлүүлэхийн тулд цөллөгт дахин төрөх нь ойлгомжтой юм. Хятадууд өөрсдийн Далай ламаа сонгож, түвдүүд бид уламжлалаа дагаж мөн л өөрсдийнхийгээ сонгох нь мэдээж. Энэ нь Банчин ламын өнөөгийн нөхцөл байдалтай адилхан. Миний сонгосон Банчин лам гэж байдаг, мөн хятадуудын томилсон Банчин лам гэж байдаг. Нэг нь Бээжингийн засгийн зорилгод үйлчилдэг бол, нөгөө нь бүх түвд үндэстний зүрхэнд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг”²³ хэмээн өөрийн хойд дүрийн үүрэг ролийг Түвдийн эрх ашгийн төлөө байх болно хэмээн тов тодорхой хэлсэн байдаг.

Ийм нөхцөл байдалд 2 Далай лам бий болох бөгөөд БНХАУ дахь буддын шашинтнууд БНХАУ-аас албан ёсоор тодруулсан Далай ламыг, бусад гадаад оронд байдаг буддын шашинтнууд Дармасала дахь төвдүүдийн тодруулсан Далай ламыг шүтэн бишрэх болж байгаа юм. Гэхдээ энэ хоёр Далай ламын алиныг нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх, дэлхийн томоохон орнууд аль Далай ламыг дэмжих, Дармасала дахь түвдүүдийн тодруулсан Далай лам олон улсын хэмжээнд ХҮ Далай лам шиг нэр хүндтэй байж чадах эсэхээс олон асуудал хамаарах юм.

ХҮ Далай лам Монгол Улсад нийтдээ 6 удаа, 1990 оноос хойш 4 удаа айлчилсан тухай бүрд нь БНХАУ-ын зүгээс ямар нэгэн эсэргүүцэл

үзүүлж байв. 2002 оны айлчлалын үеэр БНХАУ Монголтой хил залгаа төмөр замын боомтоо “тодорхойгүй шалтгаанаар” хааж эсэргүүцэж байв. Мөн энэ үеэр ОХУ-ын зүгээс “гэмтлийн улмаас” эрчим хүчний импортоо хязгаарласныг олон улсын мэдээллийн хэрэгслэлүүд бүгд Далай ламын айлчлалтай холбон тайлбарласан юм.²⁴ Иймээс Далай ламын айлчлал нь Монгол, Хятадын найрсаг харилцаатай холбоотой нэгэн эмзэг асуудал юм. Энэ талаар тухайн үед БНХАУ-аас манай улсад сууж байсан элчин сайд Хуан Жякуй “Монголд Далай лам айлчлахад Хятадын ард түмэн, үндэстнүүдийн санаа сэтгэлд хохирол учруулж, Хятад улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал юм” хэмээн “Зууны мэдээ” сонинд өгсөн ярилцлагадаа онцлон хэлсэн байдаг.²⁵

Төвдийн асуудлаар БНХАУ-ын баримталж буй бодлогыг ОХУ бүрэн дэмждэг, мөн манай улсын оюун санааны хөрш гэгддэг Энэтхэгийн Ерөнхий сайд А.Б.Важпай 2003 оны 6-р сарын сүүлчээр БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэрээ Төвдийг БНХАУ-ын салшгүй хэсэг болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн билээ.²⁶ Энэ талаар ч дээрх улсуудын адил манай улс БНХАУ-ын албан ёсны байр суурийг дэмжиж “нэг Хятад” хэмээх зарчмыг баримтлахаа албан ёсоор мэдэгдсэн, Монголын сүсэгтэн олон ч Далай ламыг шашны тэргүүн гэдэг утгаар сүсэглэн залбирч, сургаал номлолыг нь дээдлэн биширдэг билээ.

Далай ламын институт 500 гаруй жилийн түүхтэй бөгөөд нийт 14 Далай лам тодруулснаас дөрөвдүгээр Далай лам Ёндонжамц (1589-1616) нь монгол хүн, Түмэдийн Алтан хааны угсааны хүн байсан юм. Зарим судлаачид, монголын сүсэгтэн олонд дараагийн Далай ламыг Монголоос тодруулах сонирхол эрмэлзэл их байдаг. Үнэндээ сүсэгтэн олны итгэл бишрэл, хүсэл эрмэлзэлийг хорьж боох аргагүй.

Саяхан 2009 оны 10 сарын сүүлээр манай улсад айлчилсан Монголын IX Богдын айлчлал элдэв саад бэрхшээлгүй шашны хүрээнд, сүсэгт олны итгэл бишрэлийн хүрээнд нам жим болж өнгөрөв. XIY дүгээр Далай лам 1991 онд анх албан ёсоор “Халхын Богд мөн” хэмээн мутрынхаа тамгыг дарж баталгаажуулсан IX Богдыг Монголын бурханы шашны лам хувраг сүсэгтэн олон 1999 онд анх Монгол орноо урин залж байв. Сүүлийн айлчлалынхаа үеэр өөрийн хойд дүрийг Монголоос тодрохыг мөн зарласан.²⁷ Энэ нь мэдээж манай сүсэгтэн олонд таатай гэмээр мэдээ буй заа. Нөгөө талаас уламжлалт шашин буддын шашны шинэчлэлийн асуудал ихээхэн яригдаж буй өнөөгийн нөхцөлд шашны нэгэн лидер удирдагчтай болох нь ямар нэгэн маргаан зөрчилдөөнийг намжаах, саармагжуулахад ихээхэн үүрэг рольтой байж болох талтай. Эдүгээ байгаа буддын шашны томоохон мяндаг цолтон, зүтгэлтнүүдийн хувийн маргаан зөрөлдөөн, ашиг сонирхлын зөрчилдөөнд сүсэгтэн олон үнэндээ төөрөлдөж орхисон билээ.

Санал, дүгнэлт болгох нь

Төр, шашны харилцааны асуудлыг “Монгол Улсын Үндсэн Хууль” (1992), “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль” (1993), “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (1994), “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль” зэрэг хууль эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажуулсан ч амьдрал дээр төдийлөн сайн хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл шашны асуудлын эрх зүйн зохицуулалт тодорхой тайлбар шаардаж байгаагаас гадна түүнийг нэг мөр мөрдөх орчин хангалттай бус гэж ойлгож болно.

Иймд төрийн зүгээс шашны талын эрх зүйн орчныг нарийвчилсан хууль эрх зүйн акт нэмэж боловсруулан гаргахаас гадна, шашны асуудлаарх эрх зүйн актыг хэрхэн мөрдөж хэрэгжүүлэх талаар төрөөс зохицуулалт нэн даруй шаардлагатай гэж үзэж байна. Эс тэгвээс шашин хоорондын маргаан, шашны асуудлаас үүдсэн монголчуудын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах үйл явц үүсэж болзошгүй юм.

Монголчуудын шүтдэг үндэсний шашин болох бурханы шашны асуудалд монголчууд хүндэтгэлтэйгээр хандахын зэрэгцээ сүсэгтэн олон Буддын шашны тэргүүн, хувилгаан гэдэг утгаар Далай ламыг шүтэн биширч улс орондоо урин залж номлол сургаалийг нь сүсэглэдэг ч Түвдийн асуудлаас үүдэж, Хятадтай харилцах харилцаанд нөлөөлж болзошгүй гэж үзэх болгоомжлол байдгийг энд дурьдах нь зүйтэй болов уу.

Шашны асуудал нь Монголын үндэсний аюулгүй байдалтай шууд холбогдох асуудал тул төрийн зүгээс тодорхой хяналт /татварын бодлого ч юмуу, бүртгэл гэх мэт/ байх нь зүйтэй болов уу. Монгол Улс нь олон үндэстэн ястаны холбооны улс бус нэгдмэл нэг үндэстэний улс гэдгийг харгалзан үзэж, мөн хүн ам цөөн, хоёр орны дунд завсарын буфер маягаар оршиж ирсэн байдлыг бодолцон шашны асуудалд үндэсний эрх ашгийн үүднээс хандах нь зүйтэй хэмээн санана.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. О.Сарантуяа. “Шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай өнөөгийн Монголчуудын санаа бодол” илтгэл. “Шашны эрх чөлөөний Симпозиум – 2008” хурлын материал, 2008 оны 05-р сар. *“Хөдөөгийн хүн амын аж төрөх ёс” социологийн судалгааны мэдээлэл. 1986, ШУА-ийн ФСЭХ-ийн Архив.*
2. Д.Чойжамц. “Монголын бурхан шашны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”. - *Төр, сүм хийдийн харилцаа: орчин үе. Улаанбаатар, 1998, 23-р тал*
3. “Зарим сүм хийдийг сэргээн хамгаалахтай холбогдсон асуудлын тухай” БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 2-р сарын 22-ны өдрийн тогтоол №10, - *БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхэтгэл, 1990, №4*

4. С.Цэдэндамба. “Монгол Улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе), Улаанбаатар, МУИС-ийн БССТ, Лондон дахь Төвдийн фонд, 2003, 66-р тал
5. “Монголын нийгмийн өөрчлөлт”, /ред. Б.Даш-Ёндон/ УБ, 2008. 135-р тал
6. “Төр, сүм хийдийн харилцаа: орчин үе”, УБ, 1998, 47-р тал.
7. Монгол Улсын төр сүм хийдийн харилцааны тухай хууль. 2-р бүлэг 4.2-т
8. “Дорно-Өрнө” сэтгүүл, 1994, №2, 5-р тал
9. “Дорно-Өрнө” сэтгүүл, 1994, №2, 8-р тал
10. О.Сарантуяа. “Шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай өнөөгийн Монголчуудын санаа бодол” илтгэл. “Шашны эрх чөлөөний Симпозиум – 2008” хурлын материал, 2008 оны 05-р сар.
11. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2007”, УБ, 2008
12. Монголын нийгмийн өөрчлөлт”, /ред. Б.Даш-Ёндон/ УБ, 2008. 141-р тал
13. “Төр, сүм хийдийн харилцаа: орчин үе”, УБ, 1998, 39-р тал
14. <http://www.oloo.mn/modules.php?name=News&file=article&sid=1156163>
15. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu270503tib-2.htm>
16. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu270503tib-2.htm>
17. “Өдрийн сонин”. 2003.06.06
18. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu120603tib-1.htm>
19. http://www.montsame.mn/index.php?option=com_news&mt=normal_news&tab=200804&task=news_detail&ne=872
20. http://www.montsame.mn/index.php?option=com_news&mt=normal_news&tab=200805&task=news_detail&ne=892
21. <http://news.gogo.mn/r/45653>
22. <http://www.zuuniimedee.mn/modules.php?name=News&file=article&sid=3417&catid=4>
23. “Зууны мэдээ” сонин. 2005.12.15
24. Б.Содон. “Далай лам: шашин, улс төр”. “Стратеги судлал” сэтгүүл. 2002. №2, х.205
25. “Зууны мэдээ”. 2003.10.09
26. “Зууны мэдээ”. 2003.06.26, “Өдрийн сонин”. 2003.06.26
27. <http://news.gogo.mn/r/61777>